



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2026.01.06 № А4/28

танай _____-ны № _____-т

**“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦЖЖТ КОМПАНИД**


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дүгээр сарын 26-ны өдрийн 885 дугаар тогтоолыг хүргүүлж байна.

Тогтоолын хэрэгжилтийг ханган, биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001419

A-5/2026



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 885

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 123,941,789.20 төгрөг (нэг зуун хорин гурван сая есөн зуун дөчин нэгэн мянга долоон зуун наян есөн төгрөг хорин мөнгө)-ийн балансын үнэ, 13,535,861.65 төгрөг (арван гурван сая таван зуун гучин таван мянга найман зуун жаран нэгэн төгрөг жаран таван мөнгө)-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг “Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид хавсралтад заасны дагуу шилжүүлсүгэй.

2. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Даваадалай, “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэн, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Х.Ганчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системд бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002987
28-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 1-дугаар сарын 28-ны өдрийн
 88.5 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 "БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД
 ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал - тад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	"Бор-Өндөр" УБҮ-ийн Өргөн хэсгийн 35/10кВ дэд станцын 10кВ хувиарлах байгууламж	12/31/1988	ш	1	123,941,789.20	13,535,861.65	110,405,927.55
					123,941,789.20 (нэг зуун хорин гурван сая есөн зуун дөчин нэгэн мянга долоон зуун наян есөн төгрөг хорин мөнгө)	13,535,861.65 (арван гурван сая таван зуун гучин таван мянга найман зуун жаран нэгэн төгрөг жаран төвөн мөнгө)	110,405,927.55 (нэг зуун арван сая дөрвөн зуун таван мянга есөн зуун хорин долоон төгрөг тавин таван мөнгө)